



СӨНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН АЛБАН ДААЛГАВАР

2017 оны 11 сарын 24

Дугаар 02

Улаанбаатар

Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай

Тус дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны А/102 дугаар тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дүүргийн Татварын хэлтэс, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагаатай танилцан тэдний санаа бодлыг судлан дүүргийн орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулах ажлын санал гаргасныг Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн хурлаар авч хэлэлцээд орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн дээрх Ажлын хэсгээс гаргасан ажлын саналыг бодит ажил хэрэг болгох зорилгоор Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 20.1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ДААЛГАХ нь:

1. Дүүргийн Засаг дарга Ж.Сандагсүрэнд:

1.1 Дүүргийн Засаг даргаас хорооны Засаг даргатай бүрэн эрхийн хүрээнд хамтарч ажиллах “Батламж”-ийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргуулан үйл ажиллагааг нь дүгнэхдээ орон тооны бус татварын байцаагчтай ажлаа хэрхэн уялдуулж, үр дүн гаргасан байдлыг харгалзан үзэх

1.2 Иргэний орлогын албан татвараа төлөөгүй иргэнд хариуцлага тооцох улсын байцаагчийн эрхийг Орон тооны бус татварын байцаагч нарт олгож болох эрх зүйн орчныг судалж, холбогдох дээд байгууллагад уламжлах

1.3 хоёр буюу түүнээс дээш үл хөдлөх хөрөнгийн орон сууцны гэрчилгээг эзэмшиж буй дүүргийн иргэдийн судалгааг холбогдох байгууллагаар гаргуулан Сууц өмчлөгчдийн холбооноос тухайн орон сууцанд амьдарч буй иргэдтэй байгуулсан

гэрээг тулган орон сууцны байр түрээслүүлэгчийг тодорхойлж, дүүргийн Татварын хэлтсийг дээрх мэдээллээр хангаж ажиллах

1.4 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 21 дүгээр хорооллын Шөнийн зах, Баянхошууны эцсийн зах, Ханын материалын Хангай зах, Сутай захын бизнес эрхлэгчдийг татварын цахим системд бүртгэлжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах

1.5 Үйлдвэр үйлчилгээний тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлтийг нийслэлд уламжлах болон худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгохдоо дүүргийн Татварын хэлтсээс лавлагааг тухай бүр авч байхаар зохицуулалт хийх

1.6 Нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх зориулалтаар нийслэлээс өгдөг санхүүжилтийг дүүргийн хог тээвэрлэгч компаниуд руу шууд шилжүүлэх хүсэлтийг холбогдох дээд байгууллагад уламжлах, мөн дүүргийн төрийн сангаар дамждаг дээрх санхүүжилтийг бүрэн хуваарилах арга хэмжээг авах

1.7 Улаанбаатар хотын Захирагчийн харьяа Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-р нь тус дүүргийн нутаг дэвсгэрийн зарим нийтийн эзэмшлийн зам талбайг хариуцан үйлчилгээ үзүүлдэг байдлыг болиулж дүүргийн хог тээврийн байгууллагуудад бүрэн хариуцуулах

1.8 Тус дүүргийн 4 дүгээр хорооны Мах импекс компаний урд байрлах Аптаун вилла хотхон, 7 дугаар хорооны Хилчин хотхон, 18 дугаар хорооны Залуус хорооллын Сууц өмчлөгчдийн холбоод хогны мөнгийг хураадаг байдлыг таслан зогсоож, хог тээвэрлэгч байгууллагууд руу төвлөрүүлэх арга хэмжээг авах

1.9 Цахилгааны кодгүй өрхийн судалгааг хороо тус бүрээр гарган тэднийг хог хаягдлын хураамжид бүрэн хамруулж хэвшүүлэх ажлыг дүүргийн Татварын хэлтэстэй хамтран зохион байгуулж, татварын орон тооны бус байцаагч нартай хамтарч ажиллахыг батламжийн гэрээнд тусгах

1.10 2017 оны 12 дугаар сарын 10 дотор Мэргэжлийн, хөндлөнгийн байгууллагаар дүүргийн хог тээвэрлэлт, цэвэрлэгээ үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ОНӨААТҮГ-уудын ажлын байранд зураг авалт хийлгэж, дүгнэлтийг үндэслэн бодит тооцоог гарган санхүүжүүлж, урд онуудын өрийг үе шаттай барагдуулах

1.11 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг худалдааны төвүүд түрээслэгч нараасаа хогны хураамж авч, хог тээвэрлэгч компаниар хямд ачуулж ашигтай ажиллаж байгаад дүгнэлт хийж, түрээслэгч, хог тээвэрлэгч компани,

Татварын хэлтэстэй хамтарсан гэрээ байгуулах замаар уг асуудлыг шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээг авах

1.12 Дүүргийн ОНӨААТҮГ-уудыг ашигтай ажиллуулах бизнес төлөвлөгөөг тэдгээр байгууллагуудын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн оролцоо дэмжлэгтэйгээр боловсруулан батлуулж мөрдүүлэх, олсон ашиг орлогоороо зарлагаа нөхдөг төсвөөс санхүүжүүлэхгүй байх бодлого барьж ажиллах

2. Энэхүү албан даалгаврын биелэлтийн явцыг улирал тутам Тэргүүлэгчдийн хуралд танилцуулахыг дүүргийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Төмөрбаатар/-т даалгаж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Төсөв, санхүү эдийн засгийн ажлын хороо хариуцсан дарга /Э.Батболд/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХЦЭЦЭГ